



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
С.БАТБОЛД ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.04.12 № 05/8086  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлгийг хянасан тухай


Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Дотоод үйл ажиллагааны зохицуулалт хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Шаравсамбуугийн Мөнхбулган, Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Пүрэв-Одсэрийн Энхзул, Цахим засаглал, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Энхболдын Шаарийбуу, Автозамын асуудал хариуцсан хуулийн мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Бямбадоржийн Билгүүн нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын тавигдах шаардлагын мэргэжил хэсэгт эрх зүйч, эдийн засагч, бизнесийн удирдлага байх гэж заасныг нэр дэвшигч П.Энхзул, Дотоод үйл ажиллагааны зохицуулалт хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын тавигдах шаардлагын мэргэжил хэсэгт төрийн удирдлагын менежер эрх зүйч, эдийн засагч байх гэж заасныг нэр дэвшигч Ш.Мөнхбулган нар нь тус тус хангаагүй байгааг анхаарна уу.

Нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн нэр дэвшигч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР

0005581